

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2026.06.09

Сайншанд сум

АЛСЫН ХАРАА 2050							
№	Үндэслэж бодлогын бичиг	байгаа баримт	Арга хэмжээний нэр	Хэрэгжилт	Улсын төсөв	ОНТ	Бусад зардал
ЗОРИЛГО 3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.							
1	Арга хэмжээ 3.5.1. Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.			Тайлант хугацаанд тус газраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 7,488 иргэдийг хамруулсан. Энэхүү арга хэмжээнд шаардагдах 1,144,200 төгрөгийг зардлыг байгууллагын нийтийн биеийн тамирын идэвхтэй амьдралыг дэмжих зардлаас гаргаж, санхүүжүүлсэн. Мөн өглөө бүр 06:00-08:00 цагт бүх насны иргэдийг хамруулан алхалт, гүйлт, иог, нийтийн бүжиг, шугаман бүжиг зэрэг арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 2989 иргэн хамруулсан.	1,144,200		
2	Арга хэмжээ 3.5.2. Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.			2027 онд зохиогдох Монголын Бүх ард түмний спортын өвлийн XVII наадам, Монголын Хүүхдийн спортын өвлийн IX наадам, Монголын Хүүхдийн спортын зуны IX наадам зэрэг арга хэмжээнд аймгийн төлөөллийг оролцуулахаар бэлтгэл ажлыг төлөвлөж байна.			

3	<p>Арга хэмжээ 3.5.3. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлнэ.</p>		<p>Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 7117 иргэн хамрагдсан. Сорилын үнэлгээний дүнгээр А үнэлгээтэй 1,106 хүн /16 хувь/, В үнэлгээтэй 2,178 хүн /31 хувь/, С үнэлгээтэй 1,878 хүн /26 хувь/ тус тус үнэлэгдсэн байна. Нийт А,В,С үнэлгээтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 1.2 хувиар өссөн нь иргэдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин сайжирч байгааг харуулж байна. Сорилд хамрагдсан иргэдийн 4,061 буюу 57 хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд биеийн жингийн индексийн үзүүлэлтээр үнэлгээ хийхэд туранхай ангилал 31.1 хувь, хэвийн жинтэй ангилал 37.7 хувь, илүүдэл жинтэй ангилал 30.6 хувийг эзэлж байна.</p> <p>Мөн таргалалтын үзүүлэлтээр авч үзвэл I зэргийн таргалалттай 383 иргэн бүртгэгдсэнээс 242 нь эмэгтэй /63.2 хувь/ байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй байна. II дугаар зэргийн таргалалттай 116 иргэн бүртгэгдсэнээс 81 нь эмэгтэй /69.8 хувь/ байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 12 хувиар өссөн байна. Харин III зэргийн таргалалттай 39 иргэн бүртгэгдсэнээс 30 нь эмэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү үнэлгээний дүн нь иргэдийн бие бялдрын түвшин, эрүүл мэндийн үзүүлэлтийг насны ангиллаар тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байна.</p>	
4	<p>Арга хэмжээ 3.5.4. Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт,</p>		<p>Тус газраас Монгол Улсын Засгийн газар, Жөндөрийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриатайгаар зохион байгуулагдаж буй аяны хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <p>Байгууллагын цахим хуудсанд аяны холбогдолтой уриалгыг байршуулж, дасгалжуулагчид сагсан бөмбөг,</p>	

	сурталчилгааг нэмэгдүүлнэ.	волейбол, чөлөөт бөх, жүдо бөхийн дугуйланд хичээллэдэг өсвөрийн тамирчдад бусдын ялгаатай байдлыг буруушаах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамтлах зэрэг үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийж, аянд нэгдэж, 1200 хүнд хүргэсэн. “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, эмэгтэйчүүдийн дунд хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, хүүхдүүдийн “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриатай постертой зургийг байгууллагын цахим хаягт байршуулж аянд нэгдэж байгаагаа илэрхийлж, 1799 хүнийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.		
5	Арга хэмжээ 3.5.9. Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.	Тус газар сүүлийн үеийн дэвшилтэд технологийг байгууллагад нэвтрүүлэх биеийн тамирын арга хэмжээг олон нийтэд хүргэх үүднээс заалны гэрэлтүүлэгд 12,6 сая, шидэлтийн машин 5,8 сая төгрөг зарцуулсан. Цаашдаа байгууллагын гадна дотор талын камерын хурдыг сайжруулах, шинэчлэлт хийхээр судалгаа хийж байна.	18,4 сая	
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО				
Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)				
1	Сорилд хамрагдсан	Тайлант хугацаанд “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сорилд хамрагдсан 7117 иргэдийн үнэлгээний дүнг нэгтгэн гаргасан. Үүнээс А үнэлгээтэй 1,136 хүн 16 хувь, В үнэлгээтэй 2,376 хүн буюу 33 хувь, С		

	А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ.		үнэлгээтэй 2,106 хүн буюу 30 хувь тус тус үнэлэгдсэн байна. Нийт А,В,С үнэлгээтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 1.2 хувиар өссөн нь иргэдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинд ахиц гарч байгааг харуулж байна.		
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
1	2.1.4.1, 2.1.4.4 Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг нэмэгдүүлсэн байна.		Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2026 оны 04 дүгээр сарын 06-аас эхлэн 05 дугаар сарын 20-ны хооронд авахаар удирдамж, дүгнэх хүснэгт, авах хуваарийг албан бичгээр аймгийн хэмжээний 14 сумын нийт 187 байгууллагад төрийн мэдээллийн систем болох ERP-аар хүргүүлсэн. Үүний дагуу төрийн болон төрийн бус байгууллагуудын 03-64 насны хүн амыг хамруулахад нийт 93 байгууллагын 7117 иргэд хамрагдсан.		
2	2.1.4.2, 2.1.4.4 Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлсэн байна.		Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоо, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын дугуйлан, секцийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулагдлаа. Спортын 13 төрлийн секц дугуйланд давхардсан тоогоор 9,925 өсвөр үеийн болон, насанд хүрэгчид хамрагдсан байна. Мөн 18 байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, заалны үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр ажилласан. Үүний үр дүнд спортын зориулалтын заал, танхимаар давхардсан тоогоор 5,633 иргэн, өглөөний дасгал хөдөлгөөнд 2,305 иргэн тус тус хамрагдсан байна. Спортын тэмцээн уралдааныг сумдад 85, аймгийн төвд 64, нийт 149 удаа зохион байгуулж, 8,833 иргэнийг хамруулсан нь иргэдийн спортын идэвх оролцоог нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан үйл ажиллагаа болсон. Өсвөр үеийн болон насанд хүрэгчдийн тамирчдыг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх, тэмцээн уралдаанд	37,0 сая	

		<p>оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөсөн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Үүний хүрээнд аймгийн тамирчид Азийн аварга шалгаруулах тэмцээнд 3, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 нийт 23 удаагийн тэмцээн, уралдаанд амжилттай оролцож, 72 алт, 74 мөнгө, 58 хүрэл нийт 204 медаль хүртсэн ба нийтдээ 742 тамирчин тэмцээн, уралдаанд оролцсон нь өнгөрсөн оны мөн үеэс 17.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Мөн орон нутгийн төсвөөс тамирчдын бэлтгэл сургуулилалт, тэмцээн уралдаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд зориулан 36.0 сая төгрөгийн спортын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн нь тамирчдын амжилтыг ахиулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн болно.</p> <p>Түүнчлэн хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалтын чиглэлээр Боловсролын ерөнхий газар, Монголын Сагсан бөмбөгийн холбоо, Монголын Волейболын холбоо, Монголын чөлөөт бөхийн холбоотой хамтран нийт 13 дасгалжуулагчийг чиглэл тус бүрээрх сургалтад хамруулан, байгууллагаас 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, оролцоог ханган ажиллалаа.</p> <p>Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх оролцоо нэмэгдэж, спортын мэдлэг, хандлага, дадал төлөвшсөнөөс гадна тамирчид дасгалжуулагчдыг ур чадвар, өрсөлдөх чадвар дээшилж, тэмцээн уралдааны амжилт өмнөх оноос 1,5 хувь өссөн үзүүлэлттэй байна.</p>		
МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ				
3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ				
1	<p>3.5.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн туншлэлд</p>	<p>Өсвөр үеийн болон насанд хүрэгчдийн тамирчдыг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх, тэмцээн уралдаанд оролцох боломж нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлээ. Үүнд аймгийн өсвөрийн баг тамирчид Азийн аварга шалгаруулах 3, Улсын аварга шалгаруулах 20, нийт 23 удаагийн тэмцээн</p>	13,015,000	

	<p>суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.</p>		<p>уралдаанд амжилттай өрсөлдсөний үр дүнд 72 алт, 74 мөнгө, 58 хүрэл нийт 204 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Нийт 742 тамирчин тэмцээн уралдаанд оролцсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17,6 хувьтай өссөн үзүүлэлттэй байна. Мөн чөлөөт бөх, жүдо, жоу жицү, шатар, даам, дугуй, хөнгөн атлетик, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, сагсан бөмбөг, волейболын болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, “Gobi Guys” лиг, Хөгжлийн лиг, Ирээдүй хүүхдийн лигийн тэмцээнүүдэд 318 багийн 4473 тамирчин оролцож, 6147 гаруй үзэгч, хөгжөөн дэмжигчид үзэж сонирхсон.</p> <p>Орон нутгийн төсвөөс тамирчдын бэлтгэл сургуулилт, тэмцээн уралдаанд орох нөхцөлийг дэмжих зорилгоор 13,015,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь тамирчдын амжилтыг ахиулах, спортын хүний нөөцийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.</p>		
<p>2</p>	<p>3.5.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.</p>		<p>Тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн болон Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 25 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 9,249 иргэнийг хамрууллаа. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 1,144.2 мянган төгрөгийн зардлыг байгууллагын нийтийн биеийн тамир, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зардлаас санхүүжүүлсэн. Мөн бүх насны иргэдийн биеийн идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор өдөр бүрийн 06:00–08:00 цагийн хооронд алхалт, гүйлт, иог, нийтийн болон шугаман бүжгийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 2,989 иргэнийг хамруулсан.</p>	<p>1,144.2 мянган</p>	

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗГ-ын тогтоол

2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.

		<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд: “Нэгэн хэмнэл – Нэгэн зорилго” шугаман бүжгийн нээлттэй тэмцээнд 20 багийн 200 бүжигчин, Явган алхалтын холбооноос зохион байгуулсан хүсэл биелүүлэх ерөөлтэй “Хан Баянзүрх уул”-ын гороо алхалтад 28 иргэн, “Эрүүл агаар–2026” олон төрөлт арга хэмжээнд 8 байгууллагын 256 иргэн, “Эрүүл ажлын байрнаас – Эрүүл ажилтан” аянд 38 байгууллагын 5,455 ажилтан, албан хаагч, “Дасгал хөдөлгөөнөөр эрүүлжье” арга хэмжээнд 18 байгууллагын давхардсан тоогоор 441 иргэн, “Автомашингүй – Эрүүл ажилтан” чөлленжид 23 иргэн, “Дасгал хөдөлгөөн бол эрүүл мэндийн түлхүүр” хоёр сарын аянд 6 байгууллагын 253 иргэн, “Сайншанд марафон–2026” бүх нийтийн гүйлтэд 700 иргэн, “Сайншанд цом–2026” өсвөр үеийн унадаг дугуйн аварга шалгаруулах 9 дэх удаагийн тэмцээнд 132 тамирчин тус тус хамрагдсан. Дээрх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 7,488 иргэн оролцсон байна</p>	<p>1,649,000</p>
<p>Иргэний мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай2023.08.30Дуг аар2023_321</p>			

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл

III.2. Иргэдэд хоол, хүнсний илчлэг (калори)-ийн талаар ойлголтыг олгож зохистой хэрэглээг бий болгох, эртэч, бүтээлч, зэрэг зөв хандлагатай эрүүл амьдралын хэмнэлийг бий болгох зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар хамтран шуурхай ажиллаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний

<p>хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.</p>	<p>Аймгийн Шугаман бүжгийн холбоотой хамтран “Илүүдэл жингүй – Эртэч Монгол” хөтөлбөрийн хүрээнд иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор өглөө бүр 06:00–08:00 цагийн хооронд бүх насны иргэдийг хамарсан алхалт, гүйлт, иог, нийтийн бүжиг, шугаман бүжгийн арга хэмжээг тогтмол зохион байгуулсан. Уг арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 2989 иргэн хамрагдсан байна.</p>	<p>3Г-ын албан даалгавар</p>	<p>1.12.Эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх бодлогын реформыг хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан,Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин нарт;</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор өдөр бүрийн 06:00–08:00 цагийн хооронд иргэдийг шугаман бүжиг, нийтийн бүжиг, иогийн дасгалд хамруулан зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 2989 иргэнийг хамруулсан. Мөн байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан, эмэгтэй албан хаагчдын дунд хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа. Түүнчлэн хүүхдүүдийн “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлэе” уриатай постертой зургуудыг байгууллагын цахим хуудсанд байршуулан аянд нэгдэж байгаагаа илэрхийлж, нийт 1,799 хүнд мэдээлэл хүргэн ажилласан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Инээмсэглэл дүүрэн өдөр–2026” арга хэмжээг цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, 25 албан хаагч хүүхдүүдийн хамт оролцсон. Арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийг насны 3 ангиллаар, мөн эрэгтэй, эмэгтэй албан хаагчдыг хүүхдийн</p>
<p>1</p>	<p>2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл</p>	<p>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024.09.18 Дугаар 2024_01_1</p>	<p>3,180,000</p>

	<p>хамт оролцуулсан 5 төрлийн тэмцээн, уралдааныг Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан. Уг арга хэмжээг дэмжин Үйлдвэрчний эвлэлийн хорооноос шагналын зардалд 180.0 мянган төгрөг, 60 хүүхдийн бэлэгт 3.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд байгууллагын 52 ажилтан, албан хаагчийг дархлаажуулалтад хамруулсан.</p>		
27.27.	<p>Албан даалгаварт туссан төсөл, арга хэмжээний ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнг иргэд, олон нийтэд таниулах, Засгийн газрын нэгдсэн тайлангийн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах, шаардлагатай бэлтгэл хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p>		
2	<p>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024.09.18 Дугаар 2024_01_1</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор өдөр бүрийн 06:00–08:00 цагийн хооронд иргэдийг шугаман бүжгийн дасгалд хамруулан зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 2305 иргэнийг хамруулсан. Түүнчлэн аймгийн хэмжээнд өглөөний алхалт, гүйлт, дугуйн аялал болон фитнесийн дасгал хөдөлгөөнд тогтмол, идэвхтэй оролцдог 2989 иргэнийг бүртгэн хамруулснаар дээрх арга хэмжээнүүдэд нийт 5294 иргэн хамрагдсан байна.</p>	

ТАЙЛАН БИЧСЭН:
 НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙЧ
 ХЯНАЖ ТАНИЛЦСАН:
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОТГОНЧУЛУУН

Б.ГАНТӨМӨР